



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/150

Булган сум

“Булганд үйлдвэрлэв төв”-д
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 181.1.6 дахь заалт, 18.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Булган аймаг дахь салбараас санаачлан хэрэгжүүлж байгаа орон нутгийн бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах “Булганд үйлдвэрлэв төв”-д 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010196